



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР**

Нийцлийн аудитын тайлан

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

**ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ДОТООДЫН
ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ ХЭРЭГЖСЭН БАЙНА**

Өлгий

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	
Үндэсний Аудитын газрын харьяа Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газар	
Дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган	
Аудитын менежер Х.Женисбек	
Аудитын баг:	
Ахлах аудитор Х.Манаргүл	
Аудитор Х.Еркебулан	
Аудитор Ж.Назгүл	
Аудитор Р.Баярмаа	
2017 оны 11 дүгээр сар	
Аудитын тайланг ҮАГазрын www.audit.mn вэб сайтаас үзнэ үү.	
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 95429524, 99999844, 99668909 дугаарын утсаар харилцана уу	
ХАЯГ: Аймгийн ЗДТГазрын байр, 1 дүгээр давхар 102, 104, 217 тоот өрөө	
	Товчилсон үгийн тайлбар 3
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 4-5
	Бүлэг 1. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд бүрэн хамрагдаж, мэдээлэл хүргэх хэлбэрийг баримталсан эсэх талаар
	<i>Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдсан байна</i> 6-10
	Бүлэг 2.Хуулийн Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд шилэн дансны мэдээллийг бүрэн мэдээлж байгаа эсэх талаар
	<i>Орон нутгийн төсвийн харьяа байгууллагууд шилэн дансны тухай хуулийг хангалтгүй хэрэгжүүлсэн байна</i> 11-14
	<i>Улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж байгууллага шилэн дансны нэгдсэн санд мэдээлэл байршуулаагүй байна</i> 14-17
	Бүлэг 3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд тавих дотоодын хяналт хангалтгүй хэрэгжсэн байна.
	<i>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд тавих дотоодын хяналт хангалтгүй хэрэгжсэн байна</i> 18-20
	Бүлэг 4. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.
	<i>Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна</i> 21-22
	Дүгнэлт 23
	Зөвлөмж 24
	Холбогдох байгууллагын санал 25
	Саналд өгсөн тайлбар

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
УБГ	Улсын бүртгэлийн газар
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн Төвлөрүүлэн захирагч
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХХҮГазар	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ЦШСГ	Цахилгаан шугам сүлжээний газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
БСУГ	Боловсрол соёл урлагийн газар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудитын зорилт:

Монгол Улсын Ерөнхий аудиторт Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газраас 2017 онд нийлүүлэх аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, үр дүн”-д нийцлийн аудит хийж, дүгнэлт гарган, аудитын мөрөөр илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, санал зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийв. Үүнд:

- Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд мэдээлэл хүргэх хэлбэрийг баримтлан, бүрэн хамрагдсан эсэх
- Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд шилэн дансны мэдээллийг бүрэн мэдээлж байгаа эсэх
- Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлсэн эсэх
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх

2. Хамарсан хүрээ:

Энэхүү аудитад Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасан тус аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн хуулийн этгээдүүдийг бүрэн хамруулж, 2016 онд хийсэн 2 удаагийн аудитын дүнгээр шилэн дансны хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг бүрэн оруулсан 27 байгууллагуудад илтгэл үзүүлэн аудитаас чөлөөлж, хэрэгжилт хангалтгүй 174 байгууллагын шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 2016 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2017 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртлэх хугацааг хамруулан шалгав.

3. Үндсэн мэдээлэл:

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагууд нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 7 төрлийн мэдээлэл, 3.1.2-т заасан төрийн өмчит үйлдвэрийн газар 7 төрлийн мэдээлэл, 3.1.3-т заасан хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани 3 төрлийн мэдээллийг оруулахаар хуульчилсан.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд 2016 онд хийсэн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагч 1, төсвийн төвлөрүүлэн захирагч 14, орон нутгийн төсвийн байгууллага 144, улсын төсвийн байгууллага 35, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж 7 нийтдээ 201 байгууллагын шилэн дансны үйл

ажиллагаанд аудит хийж 4 заалт бүхий зөвлөмж, 149 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 1 албан шаардлага өгөгдсөн байна.

4. Эрсдэлийн үнэлгээ:

Аудитын төлөвлөлтийн үе шатны явцад судалсан баримт материал, хамрах хүрээ, нөхцөл байдалд хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн ерөнхий эрсдэлийг “Дунд” гэж үнэлэв.

5. Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100-400, 4000, 4100 дугаар стандартууд болон Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан хуулийг хэрэгжүүлэгч байгууллага, аж ахуйн нэгжийн нэгдсэн болон өөрийн цахим хуудас, мэдээллийн самбарт байрлуулсан мэдээллийг дансны хуулгын дүн, анхан шатны баримт, журналтай тулгах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, лавлагаа, судалгаа авах, дүн шинжилгээ хийх, газар дээр нь биет ажиглалт хийх зэрэг арга зүйг ашиглан, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

6. Аудит хийхэд ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Аудитад дараах хууль, эрхийн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.Үүнд:

- Төсвийн тухай хууль
- 2016, 2017 оны төсвийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт

7. Гүйцэтгэх хугацаа:

Аудитын талбарын ажлыг 2017 оны 10 дугаар сарын 02-ноос, тайлагналын үе шатыг 11 дүгээр сарын 15-нд эхэлж 11 дүгээр сарын 20-нд дуусгасан болно.

8. Аудитын багийн бүрэлдэхүүн:

Аудитыг ахлах аудитор Х.Манаргүл ахлаж, аудитор Х.Еркебулан, Ж.Назгүл, Р.Баярмаа нарын бүрэлдэхүүнтэй аудитын баг төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлж, аудитын тайланг бэлтгэв.

Бүлэг 1

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдсан байна.

Ерөнхий зүйл

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн нийцлийн аудитад төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит компани нийт 174 байгууллагын шилэн дансны үйл ажиллагааг хамруулав.

Аудитын төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, дэд зорилтуудын дагуу Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдаж, тэдгээр нь хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг бүрэн мэдээлж байгаа эсэхийг асуудлын шинжилгээний асуултын дагуу тулган шалгав.

Энэхүү аудитаар төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, аж ахуйн нэгж, байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагааг шилэн дансны нэгдсэн цахим хуудас болон байгууллагын өөрийн цахим хуудсанд тавьсан мэдээллийг шалгаж баталгаажуулсан.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгах аудитын төлөвлөгөөний хүрээнд Баян-Өлгий аймгийн Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан удирдамжийн дагуу 4 сумын төсөвт байгууллагуудын мэдээллийн самбар болон цахим хуудсанд байршуулсан мэдээллүүд нь холбогдох хууль, журмын дагуу үнэн зөв хөтлөгдсөн эсэхийг газар дээр нь шалгаж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, засаж залруулах, зөвлөгөө өгөх хэлбэрээр нийцлийн аудитыг хэрэгжүүллээ.

1.Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд бүрэн хамрагдаж, мэдээлэл хүргэх хэлбэрийг баримталсан эсэх талаар.

1.1 Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд бүрэн хамрагдсан эсэх талаар.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-д заасан этгээд нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдсан байна.

Шилэн дансны аудитын үр дүнгийн маягт 1-ээс үзэхэд аудитад хамрагдсан хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд буюу төсвийн ерөнхийлөн захирагч 1, төсвийн төвлөрүүлэн захирагч 14, орон нутгийн төсвийн 126, улсын төсвийн 26 байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж 7 нийт 174 аж ахуйн нэгж, байгууллага шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдсан байна.

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани, аж ахуйн нэгж тус аймагт байхгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ба шаардлагатай гэж үзвэл олон нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж байхаар заасан байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д заасан улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа 30 аж ахуйн нэгж байгууллага 2017 онд нийтдээ 4054,8 сая төгрөгийн өртөгтэй 33 төсөл арга хэмжээг гүйцэтгэсэн байна.

Дээрх 33 ажил шилэн дансны цахим хуудаст байршуулсан байдлыг шалгаж үзэхэд “Сайхан монгол өнгө” ХХК, “Асыл-али” ХХК, “Заулим-Гимарат” ХХК, “Мон-Рос Алтай” ХХК, ХХК, “Ганбарыс” ХХК, “Көркем” ХХК, “ХЗТ-Автозам” ХХК, “Монгол берри” ХХК, “Енсели орда” ХХК, “Сүвэн үүл” ХХК, “Мөнхийн тун” ХХК зэрэг аж ахуйн нэгж байгууллага 14 төсөл арга хэмжээний нийт 309,8 сая төгрөгийн мэдээллийг аймгийн Засаг даргын нэгдсэн цахим хуудсанд байршуулсан ба 19 төсөл арга хэмжээний 3745,0 сая төгрөгийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулаагүй байна.

1.2 Байгууллагууд шилэн дансны цахим хуудас, мэдээллийн самбартаа шилэн дансны мэдээлэл хүргэх хэлбэрийг баримталж мэдээлсэн эсэх талаар.

Орон нутгийн байгууллагуудын ихэнх хувь нь байгууллагын өөрийн цахим хуудасгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-д заасан орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн бүх байгууллагууд нэгдсэн цахим хуудсанд цэс нээлгэж бүртгэгдэж, мэдээллээ байршуулах боломж бүрдсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1-д “Байгууллага нь шилэн дансны мэдээллийг өөрийн цахим хуудсаар хүргэх бөгөөд цахим хуудас дараах шаардлагыг хангасан байна” гэж заасны дагуу байгууллагуудын мэдээллийг өөрийн цахим хуудсаар хүргэх үйл ажиллагаанд аудит хийлээ.

Аудитад хамрагдсан 174 байгууллагын аймгийн Засаг дарга, Цэнгэл, Булган, Сагсай, Улаанхус сум, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Гаалийн газар, ШШГАлба, УЦУОШТөв, Улсын бүртгэлийн газар, Статистикийн хэлтэс, ГХБХБГ, МСҮТөв, Авто тээвэрийн төв, Биеийн тамир спортын газар, ХХҮГазар, ЦШСГазар, аймгийн Нэгдсэн эмнэлэг зэрэг 19 байгууллага өөрийн цахим хуудастай ба бусад 152 байгууллага өөрийн цахим хуудасгүй байна.


Өөрийн цахим хуудастай байгууллагуудын цахим хуудасны шаардлагыг хангасан байдлыг шалгаж үзэхэд дараах зөрчлүүд илэрлээ: Тухайлбал:

- Аймгийн Засаг дарга өөрийн “bayan-olgi.gov.mn” цахим хуудсанд шилэн дансны цэс нээж хуулийн 5.1.1, 5.1.2, 5.1.3 дахь заалтуудыг хэрэгжүүлж ажилласан боловч 2017 оны мэдээллийг хуулийн дагуу байршуулаагүй байгаа нь шилэн дансны тухай хуулийн 4.1.1, 4.1.3 5.1.4 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.
- Сагсай, Булган сумын Засаг дарга нэр өөрийн цахим хуудсанд шилэн дансны цэс байршуулсан боловч мэдээлэл оруулаагүй байна.
- Улаанхус сумын Засаг дарга, Нэгдсэн эмнэлэг, ЦШСГазар, Биеийн тамир спортын газар зэрэг байгууллагууд өөрийн цахим хуудсанд шилэн дансны талаар мэдээлэл огт оруулаагүй байна.
- Шүүхийн тамгын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар байгууллагын цахим хуудасны шилэн дансны цэсэнд нэгдсэн цахим хуудасны хаягаа холбосон байна. Жишээ нь аймгийн Шүүхийн тамгын газрын байгууллагын өөрийн цахим хуудсан дахь шилэн дансны цэсний мэдээлэлд ороход, шилэн дансны нэгдсэн цахим хуудас автоматаар нээгдэж байгууллагын шилэн данстай холбоотой мэдээлэл харагдаж байна.
- Цагдаагийн газар нь байгууллагын цахим хуудсанд тусдаа шилэн дансны цэс нээж, уг цэсэнд бүх мэдээллийг оруулсан байна.

Зарим байгууллагын шилэн дансны мэдээллийн самбар нь хуулийн 5.8-д заасан шаардлагыг хангаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д “Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчийн шилэн дансны мэдээллийг энэ хуулийн 5.1-д заасан цахим хуудастай эсэхээс үл хамааран тухайн байгууллагын мэдээллийн самбарт байрлууна” гэж заасны дагуу аудитын явцад Буянт, Толбо, Ногооннуур, Цагааннуур зэрэг 4 сум, тосгоны төсөвт байгууллагуудад шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, мэдээллийн самбар ажиллуулж байгаа байдлыг газар дээр нь шалгаж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

Толбо сумын ЗДТГ, ИТХ, ЭМТөв, бүрэн дунд сургууль, хүүхдийн цэцэрлэг, соёлын төв Буянт сумын Соёлын төвөөс бусад, Цагааннуур тосгоны бүх байгууллагууд нь шилэн дансны мэдээллийн самбарт ОНХСангийн төлөвлөгөө, гүйцэтгэл, батлагдсан орон тоо, дараа жилийн төсвийн төсөлд өгсөн саналыг батлагдсан төсөв, аудитын дүгнэлт, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээллийг шилэн дансны мэдээллийн самбарт байршуулж, Шилэн дансны тухай хуулийн 5.8-д заасныг хангаж ажилласан байна.



Бусад сумуудад шилэн дансны мэдээллийн самбартай холбоотой дараах зөрчил илэрлээ. Тухайлбал:

- Ногооннуур сумын Засаг даргын тамгын газрын шилэн дансны мэдээллийн самбарт сар бүрийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэлийн мэдээлэл, ОНХСангийн төлөвлөгөөнөөс бусад мэдээлэл байршуулаагүй байна.
- Ногооннуур сумын хүүхдийн цэцэрлэгийн шилэн дансны мэдээллийн самбарт байгууллагын батлагдсан орон тоо, аудитын дүгнэлт, дараа жилийн төсвийн төсөлд өгсөн саналыг байршуулаагүй.
- Ногооннуур сумын бүрэн дунд сургуульд тусдаа мэдээллийн самбаргүй, байгууллагын багш нарын мэдээллийн самбарын 2 нүдийг ашиглаж мэдээлэл оруулдаг боловч байгууллагын батлагдсан бүтэц орон тоо, аудитын дүгнэлт, дараа жилийн төсвийн төсөлд өгсөн саналыг байршуулаагүй байна.
- Буянт, Ногооннуур сумын Соёлын төв мэдээллийн самбар ажиллуулаагүй Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7, 5.8 дахь заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Зарим байгууллагын дарга, санхүүгийн ажилтаны нэрийг оруулж мэдээллийг шинэчлээгүй байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Баяннуур сумын ахлах сургууль, ХХҮГазар, Стандартчилал хэмжил зүйн хэлтэс, Зоноосын өвчин судлалын төв, Сум дундын ойн анги, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Бугат, Ногооннуур, Толбо, Өлгий сумдын төсвийн төвлөрүүлэн захирагч зэрэг байгууллагууд цахим хуудсанд байгууллагын дарга, санхүүгийн ажилтны, аймгийн Засаг дарга, ЦШСГазар санхүүгийн ажилтны нэрийг шинэчилж оруулаагүй шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “Тодруулга өгөх албан тушаалтны нэр, утас, цахим хаягийг байршуулсан байх”, 5.1.4-т “Мэдээллийг тогтмол шинэчилж байх” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Орон нутгийн төсвийн байгууллагуудаас Баяннуур, Бугат, Булган, Ногооннуур, Улаанхус сумын төсөвт байгууллагууд, Өлгий сумын 4-р бүрэн дунд сургууль, Хотгор бага сургууль, 10, 17 дугаар хүүхдийн цэцэрлэг, “Мейрим”, “Раушан”, “Жансая”, “Шипагер” өрхийн эмнэлэг, Цэнгэл сумын 3-р цэцэрлэг, Толбо сумын цэцэрлэг, соёлын төв, ОНОНРТелевиз зэрэг байгууллага, улсын төсвийн

байгууллагуудаас Стандартчилал, хэмжил зүйн хэлтэс, ХХҮГазар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Зоноосын өвчин судлалын төв, Дэлүүн сумын сум дундын эмнэлэг зэрэг нийт 49 байгууллага шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байгууллагын зургийг оруулаагүй байна.

Бүлэг 2

Орон нутгийн төсвийн харьяа байгууллагууд шилэн дансны тухай хуулийг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

2. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд шилэн дансны мэдээллийг бүрэн мэдээлж байгаа эсэх талаар.

2.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээд, төрийн өмчийн үйлдвэрийн газрууд шилэн дансны мэдээллийг хуульд заасан шаардлагын дагуу хугацаанд нь тогтмол мэдээлсэн эсэх талаар.

- Шилэн дансны тухай хуулийн 6.1.1-д заасан мэдээллийг тогтмол мэдээлсэн эсэх талаар.

Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээд, төрийн өмчийн үйлдвэрийн газрууд шилэн дансны зарим мэдээллийг хуульд заасан шаардлагын дагуу хугацаанд нь тогтмол мэдээлээгүй байна.

Аудитад улсын төсвийн байгууллага 26, орон нутгийн төсвийн байгууллага 141, ОНӨААТҮГазар 4, Төрийн өмчит үйлдвэрийн газар 3 бүгд 174 байгууллага хамрагдсан.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасан тухайн жилийн төсвийг мэдээлбэл зохих 169 байгууллагаас 38,5 хувь буюу 65 нь, ОНХС-ийн төлөвлөгөөг мэдээлбэл зохих 15 байгууллагаас 66.7 хувь буюу 10 нь, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг мэдээлбэл зохих 15 байгууллагаас 63.2 хувь буюу 12 нь мэдээлээгүй байна. Тухайлбал:

- Аймгийн Шүүх, Зэвсэгт хүчний 340-р анги, Дэлүүн сумын Сум дундын эмнэлэг, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, аймгийн ТЕЗ, Дэлүүн сумын ТТЗ бусад бүх сумын ТТЗ, Асрамжийн газар, Аймгийн ЗДТГазар, Орон нутгийн олон нийтийн радио телевиз, Хөгжимт драмын театр, Байгаль орчны газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Насан туршийн боловсролын төв, Алтай сумын Ахлах сургууль, Баяннуур сумын Соёлын төв, Булган, Ногооннуур сумын бүх төсөвт байгууллага, Буянт сумын ИТХ, ЗДТГазар, Сагсай сумын ЭМТөв, хүүхдийн цэцэрлэг, Толбо сумын ИТХурал, ЗДТГазар, ЭМТөв, Хүүхдийн Цэцэрлэг, Соёлын төв, Цагааннуур тосгоны Захирагчийн алба, Цэнгэл сумын Тыва бага сургууль, 2-р цэцэрлэг, Өлгий сумын 1, 4-р бүрэн дунд сургууль, 2-р бага сургууль, Хотгор бага сургууль, 5, 10, 13-р хүүхдийн цэцэрлэг, Хотгор цэцэрлэг, "Эрдэм" цогцолбор цэцэрлэг бага сургууль, "Жана өлкө" ОНӨААТҮГазар зэрэг 64 байгууллага тухайн жилийн төсвийг байршуулаагүй.
- Хүнс, хөдөө аж ахуйн газар, Дэлүүн, Ногооннуур сумын Сум дундын эмнэлэг, Ногооннуур, Баяннуур сумын хүүхдийн цэцэрлэг, Улаанхус сумын ЭМТ, Хилийн цэргийн 0258-р анги, Асрамжийн газар, Өлгий "Сансар" эмнэлэг,

НТБТөв, Алтай, Сагсай сумын ЭМТөв, Цагааннуур тосгоны Захирагчийн алба, соёлын төв, хүүхдийн цэцэрлэг, Өлгий сумын 2, 7, 8, 9, 13, 17, 18 дугаар хүүхдийн цэцэрлэгүүд зэрэг 21 байгууллага мэдээллээ хугацаа хожимдуулж оруулан Шилэн дансны тухай хуулийн 6.1.1 дэх заалтыг зөрчсөн байна.

- Аймгийн ТЕЗ, Баяннуур, Бугат, Булган, Буянт, Ногооннуур, Толбо, Улаанхус, Өлгий сум, Цагааннуур тосгоны ТТЗ зэрэг 10 байгууллага ОНХС-ийн төлөвлөгөөг байршуулаагүй,
- Аймгийн ТЕЗ, Алтанцөгц, Баяннуур, Бугат, Булган, Буянт, Ногооннуур, Толбо, Улаанхус, Өлгий сум, Цагааннуур тосгоны ТТЗ зэрэг 11 байгууллага худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг байршуулаагүй шилэн дансны тухай хуулийн 6.1.1 дэх заалтыг зөрчсөн байна.

- Шилэн дансны тухай хуулийн 6.1.2-т заасан мэдээлэлийг тогтмол мэдээлсэн эсэх талаар.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-д заасан сарын төсвийн гүйцэтгэлийг мэдээлбэл зохих 148 байгууллагаас 46 байгууллага буюу 31 хувь нь мэдээлээгүй байна. Сарын төсвийн гүйцэтгэлийг сарын мэдээг дутуу оруулсан байгууллагуудыг авч үзвэл:

- Онцгой байдлын газар, Зоноосын өвчин судлалын төв, Цэнгэл 3-р цэцэрлэг, Өлгий сумын Насан туршийн боловсролын төв, 18-р цэцэрлэг 2-3 сарын,
- Алтанцөгц сумын цэцэрлэг, Өлгий сумын 1-р бүрэн дунд сургууль, 4-р цэцэрлэг, Цэнгэл ИТХурал, ЗДТГазар, Аймгийн ЗДТГазар, Биеийн тамир спортын газар 4-6 сарын,
- Зэвсэгт хүчний 331-р анги, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Сагсай сумын Даян бага сургууль, Цэнгэл сумын соёлын төв, Өлгий сумын ИТХурал, ЗДТГазар, 11, 13,16-р цэцэрлэг, Стандартчлал, хэмжил зүйн хэлтэс, Зэвсэгт хүчний 340-р анги, Хотгор бага сургууль, Орон нутгийн олон нийтийн радио телевиз, Ногооннуур сумын Чихтэй, Ховд, Уланчулуут бага сургуулиуд, Толбо сумын ЭМТөв, Ногооннуур сумын ИТХурал, ЗДТГазар 8-9 сарын,
- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Өлгий сумын 3-р цэцэрлэг, Дэлүүн сумын сум дундын эмнэлэг, Ногооннуур хүүхдийн цэцэрлэг, Толбо ИТХурал, ЗДТГазар 10-11 сарын мэдээллүүдийг дутуу оруулсан байна.
- Булган сумын ИТХурал, ЗДТГазар, ЭМТөв, хүүхдийн цэцэрлэг, Ёлт бага сургууль, Ёлт хүүхдийн цэцэрлэг, Буянт сумын ИТХурал, Сагсай цэцэрлэг, Толбо ахлах сургууль, хүүхдийн цэцэрлэг, соёлын төв, Асрамжийн газар зэрэг байгууллагууд 12 сарын төсвийн гүйцэтгэлийг огт оруулаагүй байгаа нь хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-д заасан “..... сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны дотор” оруулна гэсэн заалтыг зөрчиж ажилласан байна.

Улсын төсвийн 13 байгууллага, орон нутгийн төсвийн байгууллага 47, ТӨААТҮГ-ын 2 нийтдээ 62 байгууллага төсвийн гүйцэтгэлийн мэдээллийг хугацаа хожимдуулж оруулан хуулийн 4.1.3, 6.1.2 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

- Шилэн дансны тухай хуулийн 6.1.3-т заасан мэдээллийг тогтмол мэдээлсэн эсэх талаар.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-д заасан дараа жилийн төсвийн төслийг мэдээлбэл зохих 168 байгууллагаас 101 байгууллага буюу 60.1 хувь нь мэдээлээгүй шилэн дансны хуулийг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Аудитын үр дүнгийн маягт №1-ээс байгууллагын төрлөөр нь авч үзэхэд улсын төсвийн 9 байгууллага, орон нутгийн төсвийн 89 байгууллага, 3 ОНӨААТҮГ газар дараа жилийн төсвийн төслийг мэдээлээгүй байна.

- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Гаалийн газар, ШШГАЛба, Асрамжийн газар, НТБТөв, Алтай сумын ИТХурал, Хүүхдийн цэцэрлэг, ХТАлба, 6-р бүрэн дунд сургууль, Өлгий сумын 7-р цэцэрлэг зэрэг 10 байгууллага дараа жилийн төсвийн төсөлийн мэдээллийг хуулийн хугацаандаа оруулаагүй хуулийн 6.1.3 дэх заалтыг зөрчсөн байна.

- Шилэн дансны тухай хуулийн 6.1.4-т заасан мэдээлийг тогтмол мэдээлсэн эсэх талаар.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-т заасан хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн тайланг мэдээлбэл зохих 169 байгууллагаас жилийн эцсийн санхүүгийн тайланг 65 байгууллага буюу 38.5 хувь нь, хагас жилийн санхүүгийн тайланг 75 байгууллага буюу 44.4 хувь нь мэдээлээгүй байна.

2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2 сумын ТТЗ, улсын төсвийн 20 байгууллага, орон нутгийн төсвийн байгууллага 78, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж 1, ТӨААТҮГ-ын 3 нийтдээ 104 байгууллага байршуулсан байна.

2017 оны хагас жилийн санхүүгийн тайланг 1 сумын ТТЗ, улсын төсвийн 20 байгууллага, орон нутгийн төсвийн байгууллага 70, ТӨААТҮГ-ын 3 нийтдээ 94 байгууллага мэдээлжээ.

- Байгаль орчны газар, Татварын хэлтэс, Боловсрол, соёл, урлагийн газар, ШШГАЛба, Бугат сумын ИТХ, ЭМТ, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Цэнгэл сумын Ахлах сургууль, Тува бага сургууль, 1-р цэцэрлэг, Өлгий сумын 13-р цэцэрлэг зэрэг 12 байгууллага 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг, ГХБХБГазар, ХДТеатр зэрэг байгууллагууд 2017 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг хугацаа хожимдуулж байршуулж хуулийн 4.1.3, 6.1.4 дэхь заалтыг тус тус зөрчсөн байна.

- Шилэн дансны тухай хуулийн 6.1.5-д заасан мэдээлийг тогтмол мэдээлсэн эсэх талаар.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5-т заасан ТЕЗ-ын төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг мэдээлбэл зохих 167 байгууллагаас 69 байгууллага буюу 41.3 хувь нь, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг мэдээлбэл зохих 50 байгууллагаас 47 байгууллага мэдээлээгүй байна.

ТЕЗ-ын төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг 2 сумын ТТЗ, улсын төсвийн 16 байгууллага, орон нутгийн төсвийн байгууллага 77, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж 1, ТӨААТҮГ-ын 2 нийтдээ 98 байгууллага байршуулсан байна.

Аймгийн ЗДТГазар, Байгаль орчны газар, аймгийн Татварын хэлтэс, УЦУОШТөв, Буянт, Дэлүүн сумын Засаг дарга зэрэг 6 байгууллага аудитын дүгнэлтийг тухайн жилийн 4-р сарын 25-ны дотор мэдээлэх ёстой боловч хугацаа хожимдуулан оруулж хуулийн 4.1.3, 6.1.5 дахь заалтыг зөрчжээ.

- Шилэн дансны тухай хуулийн 6.1.6-д заасан мэдээлийг тогтмол мэдээлсэн эсэх талаар.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6-т заасан төсвийн хэмнэлт хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг мэдээлбэл зохих 167 байгууллагаас 58 байгууллага буюу 34.7 хувь нь мэдээлээгүй байна.

Төсвийн хэмнэлт хэтрэлтийг 4 сумын ТТЗ, улсын төсвийн 20 байгууллага, орон нутгийн төсвийн байгууллага 83, ТӨААТҮГ-ын 2 нийтдээ 109 байгууллага байршуулсан байна.

2.2. Төрийн болон орон нутгийн өмчит этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд 7 хоногийн дотор мэдээлэх мэдээллийг тогтмол мэдээлсэн эсэх талаар.

Шилэн дансны тухай хуулийн 3.1.1,3.1.2 дахь хэсэгт заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт заасан зарим мэдээллийг бүрэн байршуулаагүй байна.

- Шилэн дансны тухай хуулийн 6.4.1-д заасан мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлсэн эсэх талаар.

Шилэн дансны аудитын үр дүнгийн маягт №2-оос үзэхэд хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д заасан төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг мэдээлбэл зохих 167 байгууллагаас 152 байгууллага буюу 91,0 хувь мэдээллийг байршуулсан боловч дараах зөрчил илэрлээ.

Амгийн ТЕЗ, аймгийн Шүүхийн тамгын газар, Өлгий, Баяннуур, Булган, Дэлүүн, Ногооннуур, Толбо, Улаанхус, Буянт, Цагааннур тосгоны ТТЗ, Насан туршийн боловсролын төв, Цахилган шугам сүлжээний газар зэрэг 15 байгууллагын төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг мэдээлж байршуулаагүй байна.

Аймгийн ШШАлба, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Статистикийн хэлтэс, НТБТөв, ОНӨГазар, Алтай сумын Ахлах сургууль, Хүүхдийн цэцэрлэг зэрэг 7 байгууллага тухай жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг хугацаа хожимдуулан мэдээлж 6.4.1 дэхь заалтыг зөрчсөн байна.

- Шилэн дансны тухай хуулийн 6.4.2-т заасан мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлсэн эсэх талаар.

Орон нутгийн олон нийтийн радио телевиз, "Хала-Өркени" ОНӨААТҮГ, Орон нутгийн нисэх буудал зэрэг 3 байгууллага хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийг мэдээлсэн байна

- Шилэн дансны тухай хуулийн 6.4.3-т заасан мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлсэн эсэх талаар.

Шилэн дансны тухай хуулийн 6.4.3-т “Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан” болно гэж заасны дагуу ил тод байдлыг хангахын тулд www.tender.bo.gov.mn, www.tender.gov.mn, www.bayan-ulqii.gov.mn сайтуудад болон Монголын үнэн сонинд тендерийн урилгыг зарлаж олон нийтэд мэдээлсэн байна.

- Шилэн дансны тухай хуулийн 6.4.4-т заасан мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлсэн эсэх талаар.

Таван сая төгрөгнөөс дээш үнэ бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээтэй холбоотой мэдээлэл 141 байгууллагад хамааралгүй байна.

Мэдээлэх ёстой 33 байгууллагад 405 гүйлгээ гарснаас 203 гүйлгээ буюу 2751,4 сая төгрөгийн мэдээллийг цахим хуудсанд байршуулсан бол 18 байгууллагын 6700.0 сая төгрөгийн 202 гүйлгээг мэдээлээгүй байгаа нь хуулийн 6.4.4 дэх заалтыг хангалтгүй хэрэгжүүлж байгаатай холбоотой байна.

- Шилэн дансны тухай хуулийн 6.4.5-д заасан мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлсэн эсэх талаар.

Аудитад хамрагдсан байгууллагууд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1620 гүйлгээний нийт 69778.2 сая төгрөгийн орлогоос 1524 гүйлгээний 65045.5 сая төгрөгийн орлогын гүйлгээг байршуулаагүй байна. Энэ нь мэдээлвэл зохих нийт орлогын 94,1 хувийг эзлэж байна.

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээгээр гарсан 583 гүйлгээнээс 5940.9 сая төгрөгийн 268 гүйлгээний зарлагыг мэдээлээгүй байна.

- ОБГазар, Аймгийн Нэгдсэн эмнэлэг, ЦШСГазар, ШШГАлба, Хилийн цэргийн 0285-р анги, Улсын бүртгэлийн хэлтэс, МСҮТөв, Алтай, Дэлүүн сумын Засаг дарга, Өлгий “Сансар” эмнэлэг, ГБХЗХТөв, НТБТөв, ОНӨГазар, Алтай сумын Ахлах сургууль, Улаанхад Бага сургууль, хүүхдийн цэцэрлэг, ЭМТөв, Сагсай сумын Ахлах сургууль, Цагааннуур Захирагчийн алба, Соёлын төв, Дунд сургууль, Өлгий сумын ИТХурал, ЗДТГазар, ХТАлба, 7, 13, 16-р хүүхдийн цэцэрлэг зэрэг 27 байгууллага цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг хугацаа хожимдуулан мэдээлж хуулийн 6.4.5 дахь заалтыг зөрчсөн байна.

- Шилэн дансны тухай хуулийн 6.4.6-д заасан мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлсэн эсэх талаар.

Худалдан авалтын аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнтэй холбоотой үйл ажиллагаа бүх байгууллагад гараагүй байна.

- Шилэн дансны тухай хуулийн 6.4.7-д заасан мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлсэн эсэх талаар.

Байгууллагуудын батлагдсан орон тоонд гарсан өөрчлөлтийг 111 байгууллага мэдээллийн санд байршуулж, 38 байгууллага мэдээллээ байршуулаагүй байгаа ба 25 байгууллагад орон тооны ямар нэгэн өөрчлөлт гараагүй байна.

- Шилэн дансны тухай хуулийн 6.4.8-д заасан мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлсэн эсэх талаар.

Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэлийн талаарх шийдвэр, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ хамааралгүй байсан ба концессийн болон авлага үүссэн шийдвэрийн талаарх мэдээлэл бүх байгууллагад гараагүй байна.

Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн талаарх мэдээллийг 5 байгууллага мэдээллийн санд байршуулаагүй байсан бол 169 байгууллагад төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах тухай ямар нэгэн шийдвэр гараагүй байна.

- Шилэн дансны тухай хуулийн 6.4.9-д заасан бусад мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлсэн эсэх талаар.

Хууль тогтоомжид заасан бусад мэдээлэлийн талаар байгууллагуудад мэдээлэл гараагүй байна.

2.4. Хяналтын багц буюу түнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компаниуд шилэн дансны мэдээллийг хуульд заасан шаадлагын дагуу хугацаанд нь тогтмол мэдээлсэн эсэх талаар.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан хяналтын багц буюу түнээс дээш хэмжээний хувьцааг төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани, аж ахуйн нэгж тус аймагт байхгүй байна.

2.5. Улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж байгууллага болон төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллагууд шилэн дансны мэдээллийг хуульд заасан шаардлагын дагуу хугацаанд нь тогтмол мэдээлсэн эсэх талаар.

Улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж байгууллага шилэн дансны нэгдсэн санд мэдээлэл байршуулаагүй байна.

Шилэн дансны үр дүнгийн маягт №4-өөс үзэхэд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3465,6 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээ, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 172,2 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээ, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 286,7 сая төгрөгийн 15 төсөл арга хэмжээ, замын тусгай сангийн хөрөнгөөр 130,3 сая төгрөгийн 8 төсөл арга хэмжээ нийтдээ 4054,8 сая төгрөгийн 33 төсөл арга хэмжээг гүйцэтгэсэн байна.

Үүнээс улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц үе шат, зарлага санхүүжилтийн талаарх улирал бүрийн мэдээллийг дараа сарын 15-ны дотор Засгийн газрын 29 дүгээр тогтоолоор батлагдсан журмын хавсралт маягтын дагуу аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, иргэн гэсэн цэсэнд байршуулж мэдээлж байх ёстой атал 22 аж ахуйн нэгж, байгууллага 3982,9 сая төгрөгийн санхүүжилтийг мэдээлээгүй хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд хийсэн нийцлийн аудитын явцад Сангийн яамны “mof.gov.mn” сайтад сумдын ОНХСангийн мэдээлэл байршуулсан байдлыг шалгаж үзэхэд тус сайтад аймгийн болон 13 сум, 1 тосгоны ОНХСангийн цэс нээгдэж мэдээллийг хэрэгжих төсөл хөтөлбөрийн нэрээр болон сар бүр төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг үнийн дүнгээр оруулсан байна.

Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч 12 байгууллага шилэн дансны нэгдсэн санд мэдээллээ байршуулаагүй байна.

Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллага санхүүжилтийн талаарх улирал бүрийн мэдээллийг дараа сарын 15-ны дотор Засгийн газрын 29 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, иргэн гэсэн цэсэнд байршуулж мэдээлж байх ёстой атал мэдээлээгүй шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дахь заалтыг зөрчсөн байна.

Аймгийн хэмжээнд хувийн хэвшлийн Ерөнхий боловсролын 6 сургууль, 6 цэцэрлэг нийтдээ 12 байгууллага тусгай зөвшөөрлийн дагуу боловсролын үйл ажиллагаа явуулж, оны эхнээс эдгээр байгууллагуудад нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын санхүүжилтээр 1195,4 сая төгрөгийн санхүүжилт олгогджээ.

Шилэн дансны нэгдсэн санд хувийн хэвшлийн сургууль, цэцэрлэгүүдийн мэдээлэл тавьсан эсхийг шалгаж үзэхэд “shilen dans.gov.mn” нэгдсэн санд байршуулбал зохих мэдээллийг огт байршуулаагүй бөгөөд энэ талаар өмнөх онд хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Бүлэг 3

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд тавих дотоодын хяналт хангалтгүй хэрэгжсэн байна.

3. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлсэн эсэх талаар.

3.1. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлсэн эсэх талаар.

Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд аймгийн ИТХ-аас хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

8.1-д “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн хурал,хэрэгжүүлнэ” гэж заасан боловч аймгийн ИТХурлын ажлын албанаас 2017 оны 11 дүгээр сарын 08-ний өдрийн 01/359 тоот албан бичигт аймгийн ИТХ-аас 2016, 2017 онуудад Шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн ямар нэгэн хяналтын ажил зохион байгуулаагүй байгааг дурдсан байна.

3.2. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн шилэн дансны үйл ажиллагаанд төсвийн ерөнхий захирагчийн дотоод хяналтыг хэрэгжүүлсэн эсэх талаар.

Төсвийн ерөнхий захирагчийн дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ”, түүнчлэн Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 8.5-д “Төсвийн ерөнхийлөн захирагч /дотоод аудитын алба/ нь шилэн дансны үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана” гэж заасны дагуу Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь шилэн дансны хуулийн хэрэгжилт, үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас доорхи ажлуудыг зохион байгуулж ажилласан байна. Үүнд:

- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ болон төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг аж ахуйн нэгж байгууллага шилэн дансны нэгдсэн санд мэдээллээ нөхөж байршуулах талаар холбогдох албан тушаалтанд танилцуулж, Шилэн дансны тухай хуулийг ханган ажиллах талаар чиглэл өгч ажилласан.

- 2016 оны 4 дүгээр улирал болон 2017 оны эхний 10 сарын байдлаар 85 төсвийн байгууллагын шилэн дансны цахим хуудас, мэдээллийн самбартаа шилэн дансны мэдээллийг хугацаанд байршуулж байгаа эсэхэд хяналт тавьж, зөвлөгөө өгч ажилласан байна.
- Сангийн яамнаас өгсөн чиглэлийн дагуу “Улирал бүр тайлан илгээсэн эсэх” байдлыг хянах зааварчилгаа, ТЕЗ-ийн “аудитын эрх”-ийг бүх сумдын харьяа төсөвт байгууллагуудад цахимаар хүргүүлж, сумдын ТЕЗ-ийн Шилэн дансны хэрэгжилтийг ханган ажиллах талаар хамтран ажил зохион байгуулан шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэлийг Сангийн яамнаас ирүүлсэн маягтын дагуу авч ажилласан байна.
- Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны улсын байцаагч нар төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалт хийх явцад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт тавьж, арга зүйгээр хангаж, зөвлөлгөө өгч аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар арга хэмжээ авч ажиллажээ.

Төсвийн захирагч нар Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 29 дүгээр тогтоолоор баталсан журмын заалтуудыг бүрэн хэрэгжүүлээгүй, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан мэдээлэл үнэн зөв, бодитой байх, иж бүрэн байх, мэдээлэл ойлгомжтой ач холбогдолтой байх, тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх зарчмыг баримталж, төсвийн ил тод байдлыг хангаж ажиллаагүй, өмнөх онд гаргасан зөрчил дутагдлуудыг давтан гаргасан зэргээс үзэхэд ТЕЗ-ийн дотоод хяналт хангалтгүй хэрэгжсэн байна.

3.3. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд ажлын тайлан дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг тусгасан эсэх талаар.

Аймгийн Засаг дарга, ЗДТГ-аас 2016 онд төсөвт байгууллагуудын ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар ямар нэгэн заалт тусгагдаагүй байна.

Харин аймгийн Засаг даргын 2017 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн А/369 тоот захирамжаар “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам” батлагдаж, журмын 10, 11 дүгээр хавсралтаар баталсан “Байгууллагууд болон Сумын засаг дарга, Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, үр дүнг тооцох шалгуур үзүүлэлт”-ийн 36, 39 дүгээр заалтад шилэн дансны мэдээллийг оруулсан байдал, авч хэрэгжүүлсэн ажлын талаар үнэлгээ хийх заалтыг оруулсан байна.

3.4. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны мэдээллийг иргэд ашиглаж, хяналт тавьсан эсэх

Аудитын явцад хийсэн судалгааны дүнгээс үзэхэд иргэд шилэнд дансны тухай хууль, шилэн дансны нэгдсэн цахим хуудасны талаар ойлголттой боловч шилэн дансны цахим хуудсыг төдийлөн сонирхдоггүй, төрийн байгууллагуудын шилэн дансны мэдээллийн самбараас тодорхой мэдээлэл авч танилцдаг байна.

Харин иргэд шилэн дансны мэдээлэлд хяналт тавьж аймаг дахь төрийн аудитын газарт өргөдөл, гомдол ирүүлсэн асуудал гаргаагүй байна.

Бүлэг 4

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

4. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх талаар:

4.1. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилтийн талаар.

Аймгийн Аудитын газраас 2016 оны 12 дугаар сард Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийгдсэн аудитын дүнгээр аймгийн Засаг даргад Шилэн дансны тухай хууль, тогтоомжийг хангалтгүй хэрэгжүүлсэн 149 төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч, орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын дарга, эрхлэгч, нягтлан бодогч нарт хариуцлага тооцуулахаар албан шаардлага хүргүүлж, хариуцлага тооцож, албан шаардлагын биелэлтийг хангуулж ажилласан байна. Тухайлбал:

Бүгд 143 албан тушаалтанаас хариуцлага тооцсоноос 11 албан тушаалтанд протоколоор сануулах, 122 албан тушаалтанд тушаалаар сануулах, 11 албан тушаалтанд цалин бууруулах арга хэмжээ авч ажилласан байна.

4.2. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн талаар.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

2016 оны 12 дугаар сард Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийгдсэн аудитын дүнгээр аймгийн Аймгийн засаг дарга А.Гылымхан, Санхүүгийн хяналт, дотоод албаны дарга Х.Хайратхан нарт шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд тавих дотоод хяналтыг эрчимжүүлж, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг бүрэн хангуулах ажил зохион байгуулж, арга хэмжээг авч ажиллах 4 заалт бүхий зөвлөмж өгөгдсөнийг биелэлтийг шалгаж үзэхэд:

Зөвлөмж 1: Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага шилэн дансны нэгдсэн санд мэдээллээ нөхөн байршуулах арга хэмжээг авах.

- Улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ болон төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг аж ахуйн нэгж, байгууллагууд шилэн дансны нэгдсэн санд мэдээллээ нөхөж байршуулах талаар холбогдох албан тушаалтанд танилцуулах, шилэн дансны тухай хуулийг ханган ажиллахыг чиглэл өгч ажилласан боловч тодорхой үр дүн гараагүй байна.

Зөвлөмж 2: Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллага мэдээллээ шилэн дансны нэгдсэн санд мэдээллээ нөхөн байршуулах арга хэмжээг авах.

- Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллага мэдээллээ шилэн дансны нэгдсэн санд мэдээллээ нөхөн байршуулах арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна.

Зөвлөмж 3: Шилэн дансны тухай хууль, эрх зүйн актуудыг сурталчилах ажлыг эрчимжүүлж, төсвийн төвлөрүүлэн захирагч, шууд захирагч, байгууллагын нягтлан бодогч нарыг нэгдсэн арга зүйгээр хангаж, аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг бүрэн арилгуулж ажиллах.

- Шилэн дансны тухай хууль, эрх зүйн актуудыг сурталчлах ажлыг эрчимжүүлж, төсвийн төвлөрүүлэн захирагч, шууд захирагч, байгууллагын нягтлан бодогч нарыг нэгдсэн арга зүйгээр хангаж, аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг бүрэн арилгуулаагүй байна.

Зөвлөмж 4: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд тавих дотоодын хяналтыг эрчимжүүлж, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг бүрэн хангуулах зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах.

- Өмнөх онд өгөгдсөн зөвлөмжийн дагуу шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд тавих дотоодын хяналтыг сайжруулж, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг бүрэн хангуулах зохион байгуулалтын арга хэмжээг авч ажилаагүй байна

Аудитын дүнгээр аймгийн Засаг даргад орон нутгийн төсвийн харьяа 49 байгууллагад 17356.4 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага, 34010.9 сая төгрөгийг зөрчил гаргасан 25 албан тушаалтанд сахилгын шийтгэл оногдуулах албан шаардлага тус тус хүргүүлэв.

Мөн улсын төсвийн 26 байгууллагад 26319.2 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлээ.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын үр дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна.

- Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдсан байна.
- Орон нутгийн төсвийн харьяа байгууллагууд шилэн дансны тухай хуулийг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд тавих дотоодын хяналт хангалтгүй хэрэгжсэн байна.
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн дор дурьдсан албан тушаалтнуудад дараах зөвлөмжийг өгч байна.

Холбогдох байгууллагын санал

Аймгийн ЗДТГ-ын санхүүгийн хяналт, аудитын албанаас ирүүлсэн санал:


**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
АУДИТЫН АЛБА**
83128 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (978) 7042-3401

2017.11.20 № 67
танай _____-ны № _____-т

Г БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР Г

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн 2017 оны эхний 10 сарын байдалд хийгдсэн нийцлийн аудитын тайлантай танилцаж үзлээ.

Уг тайлан нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн хүрээнд үнэн зөв, бүрэн хийгдсэн байна.

Харилцан мэдээлэл солилцож, хамтран ажилласан танай хамт олонд талархал илэрхийлье.

ДАРГА  Р.ХУАТХАН


ТАЙЛАНГ ХЯНАЖ БАТАЛГААЖУУЯСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  Х.ЖЕНИСБЕК

ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР  Х.МАНАРГҮЛ

АУДИТОР  Х.ЕРКЕБУЛАН

АУДИТОР  Ж.НАЗГҮЛ

АУДИТОР  Р.БАЯРМАА